



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 144 дүгээр
цэцэрлэгийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багш ажилчдаас хандивласан нийт 2,800,000 (хоёр сая найман зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг (Л.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг (Л.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 26 -ны өдрийн
А/45 дугаар тушаалын хавсралт



Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Гэр	3 ханатай	2022.04.25	Сайн	ш	1	1,100,000.00	1,100,000.00	багш ажилчид	Хандив
2	Тавилга сийлбэртэй	модон	2022.10.29	Сайн	ком	1	1,000,000.00	1,000,000.00		
3	Шүүгээ	модон	2022.10.25	Сайн	ш	14	50,000.00	700,000.00		
Тавилга эд хогшлын дүн								2,800,000.00		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								2,800,000.00		